



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 71

Улаанбаатар хот

Даатгалын компанийн бүтээгдэхүүнийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.7.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Миг даатгал” ХХК-ийн “Нотариатчийн хариуцлагын даатгал”-ын бүтээгдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, “Өмгөөлөгчийн хариуцлагын даатгал”-ын бүтээгдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус бүртгэсүгэй.


2. Даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэсэнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралтын 4.7.1-д “... Бүртгүүлсэн даатгалын бүтээгдэхүүний нөхцөл шаардлага бүхий загвараар тухайн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулна” гэж заасныг мөрдөж ажиллахыг “Миг даатгал” ХХК /Б.Мөнххишиг/-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын 1-д заасан бүтээгдэхүүний гэрээнд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, алдаатай заалт, мэдээлэл тусгасны улмаас даатгуулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Миг даатгал” ХХК /Б.Мөнххишиг/-д анхааруулсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН





Даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл

1.	Даатгалын компанийн нэр:	“Миг даатгал” ХХК
2.	Даатгалын бүтээгдэхүүний нэр:	Нотариатчийн хариуцлагын даатгал
3.	Хамаарах даатгалын хэлбэр:	Хариуцлагын даатгал
4.	Даатгалын зүйл	Даатгуулагч мэргэжлийн ажил үүргээ гүйцэтгэх явцдаа мэргэжлийн ур чадвар дутагдсанаас болон санамсар болгоомжгүйн улмаас үйлчлүүлэгчийн эд хөрөнгө, амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан тохиолдолд хуулийн дагуу хүлээх хариуцлага байна.
5.	Даатгалын эрсдэл	Даатгуулагчийн ажил мэргэжлийн алдаа, мэргэжлийн ур чадвар дутагдсанаас болон санамсар болгоомжгүйн улмаас нотариатын үйлдлийг буруу хийсэн, үйлчлүүлэгчийн хувийн байдлыг буруу тогтоосон зэрэг бусад буруутай үйлдлийн улмаас ажилдаа гаргасан алдаа, Даатгуулагч үйлчлүүлэгчийнхээ гаргасан хүсэлтийг хуульд заасан журмын дагуу хангаж ажиллаагүйгээс учирсан хохирол, зардал
6.	Даатгалын гэрээний хугацаа	Даатгалын гэрээг байгуулахдаа тусгайлан заагаагүй бол 1 жилээр байгуулна.
7.	Даатгалын гэрээний нийт бүлэг, заалтын тоо	11 бүлэг, 113 заалт
8.	Даатгалын бүтээгдэхүүн бүртгүүлэх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр:	Гүйцэтгэх захирлын 2019 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн А-19-655 тоот тушаал
9.	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Ч.Баттүшиг
10.	Даатгалын гэрээ, нөхцөл боловсруулсан:	Даатгал хариуцсан дэд захирал Д.Долгор, андеррайтер Б.Хатанбүүвэй